НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/560/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал<br>Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Я.Алтанцэцэг<br>Утас: 315093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Мөнхдэлгэр<br>Утас: 325093 Цахим хаяг: munkhdelgerd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Эрдэнэбулган<br>Утас: 325093 Цахим хаяг: erdenebulgand@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 152

танай ______ -ны № ______ -т

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах нөөц хөрөнгөөс 370.0 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 108.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 4.9 мянган төгрөг, нийт 483.7 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 483.2 сая төгрөгийг зарцуулан, 0.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1522 дугаар захирамж, хэлтсийн даргын А/28 дугаар тушаалын дагуу 2 нэр төрлийн нийт 2,451.4 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч, нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

14260S0219

**Бусад асуудал**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

***/төгрөгөөр/***

| Дансны код | Дансны нэр, төрөл | Тодруулга | 1. Эхний үлдэгдэл | 2. Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 1,819,582,349.98 | 1,623,309,782.24 |
| 33 | АВЛАГА | | 1,084,591.00 | 1,831,585.08 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 1,084,591.00 | 1,090,626.00 |
| 33500 | Бусад авлага | | - | 740,959.08 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | | - | 740,959.08 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | | 1,818,497,758.98 | 1,621,478,197.16 |
| 35100 | Түүхий эд материал | | 806,730,437.05 | 932,973,420.25 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | 806,730,437.05 | 932,973,420.25 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | 626,153,533.00 | 366,336,600.00 |
| 35400 | Хангамжийн материал | | 385,613,788.93 | 322,168,176.91 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 1,254,040.00 | 1,200,060.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 78,500,000.00 | 75,115,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | 31,367,253.00 | 33,644,170.50 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | 10,542,558.23 | 292,223.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 263,949,937.70 | 211,916,723.41 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 5,553,690,804.62 | 6,251,668,211.57 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | | 5,553,690,804.62 | 6,251,668,211.57 |
| 39200 | Биет хөрөнгө | | 5,309,467,744.62 | 6,007,445,151.57 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 1,803,792,125.50 | 2,282,036,967.50 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (201,868,249.80) | (249,712,640.16) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 7,847,577,694.44 | 10,008,475,194.44 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | (4,623,973,955.94) | (6,467,140,399.97) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | | 933,593,299.18 | 982,118,799.18 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (453,269,882.24) | (549,377,229.78) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 50,688,616.37 | 50,688,616.37 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (47,071,902.89) | (49,644,156.01) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 53,430,119.00 | 53,430,119.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (53,430,119.00) | (53,430,119.00) |
| 39300 | Биет бус хөрөнгө | | 244,223,060.00 | 244,223,060.00 |
| 39301 | Программ хангамж | | 590,000.00 | 590,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (590,000.00) | (590,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 244,223,060.00 | 244,223,060.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | | 7,373,273,154.60 | 7,874,977,993.81 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | - | 1,250.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | - | 1,250.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 41300 | Өглөг | | - | 1,250.00 |
| 41360 | Бусад өглөг | | - | 1,250.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | - | 1,250.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 7,373,273,154.60 | 7,874,976,743.81 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 7,373,273,154.60 | 7,874,976,743.81 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 969,688,177.64 | - |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | | 969,688,177.64 | - |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | - | 969,688,177.64 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 6,270,919,420.88 | 6,772,623,010.09 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 5,153,805,563.64 | 6,270,919,420.88 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 1,117,113,857.24 | 501,703,589.21 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 132,665,556.08 | 132,665,556.08 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | | 7,373,273,154.60 | 7,874,977,993.81 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

***/төгрөгөөр/***

| нсны код | Дансны нэр, төрөл | Тодруулга | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|---|
| **I Да** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | | 6,687,959,718.70 | 7,568,063,376.70 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 2,107,567,274.70 | 7,568,063,376.70 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 2,107,567,274.70 | 2,335,417,112.70 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 1,041,468,680.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 1,041,468,680.00 | - |
| 120009 | Бусад орлого | | 6,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 107,447,000.00 | 1,470,862,717.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 958,645,594.70 | 864,554,395.70 |
| 122 | Тусламжийн орлого | | 4,580,392,444.00 | 5,232,646,264.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | | 4,580,392,444.00 | 5,232,646,264.00 |
| 12211 | Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | | 3,832,300,400.00 | 4,748,944,100.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | | 3,832,300,400.00 | 4,748,944,100.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 748,092,044.00 | 483,702,164.00 |
| 122133 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 686,396,644.00 | 363,235,164.00 |
| 122134 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 55,219,000.00 | 115,517,000.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 6,476,400.00 | 4,950,000.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | | 5,570,845,861.46 | 7,066,359,787.49 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 5,570,845,861.46 | 7,066,359,787.49 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 5,539,016,234.40 | 6,965,291,001.95 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 3,366,229,869.03 | 4,235,391,005.97 |
| 210101 | Үндсэн цалин | | 3,349,720,528.03 | 4,235,391,005.97 |
| 210102 | Нэмэгдэл | | 13,646,341.00 | - |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 2,863,000.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 75,790,654.65 | 92,955,179.95 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | | 4,604,802.89 | - |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | | 541,741.34 | - |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | | 4,560,659.77 | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | | 220,818.17 | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | | 65,862,632.48 | 92,955,179.95 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 120,088,296.26 | 79,731,272.46 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 38,990,775.97 | 31,844,616.07 |
| 210302 | Түлш, халаалт | | 75,506,273.02 | 41,086,478.37 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 5,591,247.27 | 6,800,178.02 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 501,276,310.87 | 642,612,255.52 |
| 210401 | Бичиг хэрэг | | 128,670,400.00 | 150,849,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 220,191,294.00 | 260,305,022.23 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 544,237.00 | 557,704.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 137,592,979.87 | 230,899,829.29 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | 14,277,400.00 | - |
| 2105 | Нормативт зардал | | 259,318,905.00 | 981,031,373.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 990,000.00 | 442,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 195,434,600.00 | 253,354,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 62,894,305.00 | 727,234,573.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 154,249,171.00 | 34,746,803.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 40,738,671.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 42,852,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | | 70,658,500.00 | 34,746,803.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 48,256,680.00 | 82,986,667.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 43,471,600.00 | 75,548,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 2,509,800.00 | 3,560,111.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | 561,100.00 | 880,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | - | 1,469,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 1,714,180.00 | 1,529,556.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,013,806,347.59 | 815,836,445.05 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 334,313,869.00 | 42,951,135.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 679,492,478.59 | 772,885,310.05 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 31,829,627.06 | 101,068,785.54 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | | - | 89,908,785.54 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | - | 89,908,785.54 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | | - | 89,908,785.54 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\\ | | - | 76,572,256.54 |
| 2131123 | Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\\ | | - | 13,336,529.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 14,715,000.00 | 11,160,000.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | - | 10,160,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 14,715,000.00 | 1,000,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 17,114,627.06 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 14,844,972.06 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 2,263,655.00 | - |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | | 6,000.00 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 1,117,113,857.24 | 501,703,589.21 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | | 1,117,113,857.24 | 501,703,589.21 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

***/төгрөгөөр/***

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 4,580,398,444.00 | 5,232,646,264.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,580,392,444.00 | 5,232,646,264.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,832,300,400.00 | 4,748,944,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,832,300,400.00 | 4,748,944,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 748,092,044.00 | 483,702,164.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 686,396,644.00 | 363,235,164.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 55,219,000.00 | 115,517,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,476,400.00 | 4,950,000.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,566,398,444.00 | 5,232,646,264.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,566,398,444.00 | 5,232,646,264.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,531,828,816.94 | 5,131,577,478.46 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,371,266,514.68 | 4,252,819,630.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 2,008,341,514.68 | 2,555,945,230.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,182,441,000.00 | 1,524,027,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 20,801,000.00 | 44,921,200.00 |
| 210104 | Урамшуулал | 159,683,000.00 | 127,926,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 71,838,600.00 | 76,272,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 71,838,600.00 | 76,272,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 120,088,296.26 | 79,731,272.46 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 38,990,775.97 | 32,993,063.31 |
| 210302 | Түлш, халаалт | 75,506,273.02 | 40,865,423.37 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,591,247.27 | 5,872,785.78 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,675,337.00 | 46,118,804.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 381,200.00 | 413,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,000,000.00 | 41,802,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 544,237.00 | 557,704.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,749,900.00 | 3,345,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 132,020,000.00 | 162,633,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 132,020,000.00 | 162,633,300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 81,821,000.00 | 45,859,870.00 |
| 210604 | Урсгал засвар | 81,821,000.00 | 45,859,870.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 57,375,680.00 | 86,618,667.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 52,590,600.00 | 79,180,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,509,800.00 | 3,560,111.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 561,100.00 | 880,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,469,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,714,180.00 | 1,529,556.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 681,743,389.00 | 381,523,635.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 681,743,389.00 | 381,523,635.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 34,569,627.06 | 101,068,785.54 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 89,908,785.54 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 89,908,785.54 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 89,908,785.54 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 76,572,256.54 |
| 2131123 | Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\\ | - | 13,336,529.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,455,000.00 | 11,160,000.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | 10,160,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,455,000.00 | 1,000,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 17,114,627.06 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,844,972.06 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 2,263,655.00 | - |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 6,000.00 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 14,000,000.00 | - |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 14,000,000.00 | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 14,000,000.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 14,000,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 14,000,000.00 | - |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (14,000,000.00) | - |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | - | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 969,688,177.64 | 132,665,556.08 | 5,733,019,851.35 | 00.00 | 6,835,373,585.07 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 969,688,177.64 | 132,665,556.08 | 5,733,019,851.35 | 00.00 | 6,835,373,585.07 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -540,476,127.71 | 00.00 | -540,476,127.71 |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 969,688,177.64 | 132,665,556.08 | 6,270,919,420.88 | 00.00 | 7,373,273,154.60 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 969,688,177.64 | 132,665,556.08 | 6,270,919,420.88 | 00.00 | 7,373,273,154.60 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 969,688,177.64 | 132,665,556.08 | 6,270,919,420.88 | 00.00 | 7,373,273,154.60 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 501,703,589.22 | 00.00 | 501,703,589.22 |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 969,688,177.64 | 132,665,556.08 | 6,772,623,010.10 | 00.00 | 7,874,976,743.82 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 4,751,481,600.00 | 4,672,371,843.46 | 79,109,756.54 | 98.34 |
| 12 | Татварын бус орлого | 4,751,481,600.00 | 4,672,371,843.46 | 79,109,756.54 | 98.34 |
| 122 | Тусламжийн орлого | 4,751,481,600.00 | 4,672,371,843.46 | 79,109,756.54 | 98.34 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 4,751,481,600.00 | 4,672,371,843.46 | 79,109,756.54 | 98.34 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,751,481,600.00 | 4,672,371,843.46 | 79,109,756.54 | 98.34 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,751,481,600.00 | 4,672,371,843.46 | 79,109,756.54 | 98.34 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,737,362,000.00 | 4,661,211,843.46 | 76,150,156.54 | 98.39 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **4,257,839,200.00** | **4,252,819,630.00** | **5,019,570.00** | **99.88** |
| 210101 | Үндсэн цалин | 2,560,964,700.00 | 2,555,945,230.00 | 5,019,470.00 | 99.80 |
| 210102 | Нэмэгдэл | 1,524,027,200.00 | 1,524,027,200.00 | - | 100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 44,921,200.00 | 44,921,200.00 | - | 100.00 |
| 210104 | Урамшуулал | 127,926,100.00 | 127,926,000.00 | 100.00 | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **76,272,300.00** | **76,272,300.00** | **-** | **100.00** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 76,272,300.00 | 76,272,300.00 | - | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **105,077,800.00** | **79,731,272.46** | **25,346,527.54** | **75.88** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 40,048,000.00 | 32,993,063.31 | 7,054,936.69 | 82.38 |
| 210302 | Түлш, халаалт | 59,281,600.00 | 40,865,423.37 | 18,416,176.63 | 68.93 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,748,200.00 | 5,872,785.78 | (124,585.78) | 102.17 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **25,299,400.00** | **24,288,804.00** | **1,010,596.00** | **96.01** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,394,500.00 | 413,600.00 | 980,900.00 | 29.66 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,972,600.00 | 19,972,500.00 | 100.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 571,400.00 | 557,704.00 | 13,696.00 | 97.60 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,360,900.00 | 3,345,000.00 | 15,900.00 | 99.53 |
| **2105** | **Нормативт зардал** | **158,913,300.00** | **158,913,300.00** | **-** | **100.00** |
| 210502 | Хоол, хүнс | 158,913,300.00 | 158,913,300.00 | - | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **76,800,000.00** | **45,859,870.00** | **30,940,130.00** | **59.71** |
| 210604 | Урсгал засвар | 76,800,000.00 | 45,859,870.00 | 30,940,130.00 | 59.71 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **33,940,000.00** | **22,638,667.00** | **11,301,333.00** | **66.70** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,674,900.00 | 15,200,000.00 | 5,474,900.00 | 73.52 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 8,533,300.00 | 3,560,111.00 | 4,973,189.00 | 41.72 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | 3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо | 1,441,000.00 | 880,000.00 | 561,000.00 | 61.07 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,576,600.00 | 1,469,000.00 | 107,600.00 | 93.18 |
| 210807 | Газрын төлбөр | 1,714,200.00 | 1,529,556.00 | 184,644.00 | 89.23 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,220,000.00** | **688,000.00** | **2,532,000.00** | **21.37** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,220,000.00 | 688,000.00 | 2,532,000.00 | 21.37 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **14,119,600.00** | **11,160,000.00** | **2,959,600.00** | **79.04** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 14,119,600.00 | 11,160,000.00 | 2,959,600.00 | 79.04 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 10,582,100.00 | 10,160,000.00 | 422,100.00 | 96.01 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,537,500.00 | 1,000,000.00 | 2,537,500.00 | 28.27 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

***/төгрөгөөр/***

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Тайлант он |
|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 483,702,164.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 483,702,164.00 |
| 122 | Тусламжийн орлого | 483,702,164.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 483,702,164.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 483,702,164.00 |
| 350013 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 363,235,164.00 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 115,517,000.00 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,950,000.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 470,365,635.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 470,365,635.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 470,365,635.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,830,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,830,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 3,720,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 3,720,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 63,980,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 63,980,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 380,835,635.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 380,835,635.00 |
| 4 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 13,336,529.00 |
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (13,336,529.00) |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (13,336,529.00) |

## 3. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн үйл ажиллагааны чиг үүргийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн” гэж тодорхойлжээ.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь эрхэм зорилгоо “Гамшгаас хамгаалах, сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх замаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлнэ” гэж тодорхойлон дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй ажлын байрны стандартыг хэвшүүлж, ажиллах орчныг сайжруулах, хүний нөөцийн нөхөн хангалтыг нэмэгдүүлж, бүх шатны сургалтын сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх;
- Цахим технологи, инновацыг хөгжүүлж, аюулгүй байдлыг дээшлүүлэх, салбар дундын харилцан ажиллагааг сайжруулах.

## 4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 1,021,513.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

## 5. Дараагийн аудитаар анхаарах асуудал

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар:

Онцгой байдлын байгууллагын оны шилдэг алба хаагчийг шагнаж урамшуулах журмыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын “Төрийн албан хаагчид шагнал олгох” журамд нийцүүлэн баталж мөрдүүлэх талаар анхаарах.

## 6. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 22.0 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 32,194.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 1,712.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 30,481.5 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 32,194.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 7. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бичиг хэргийн материал зөрүүтэй тайлагнасан байна. | 1 | 22.0 | 1 | 22.0 | | | 1 | 22.0 | | | | |
| Дүн | 1 | 22.0 | 1 | 22.0 | | | 1 | 22.0 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс Төлбөрийн акт | | Үүнээс Албан шаардлага | | Үүнээс Зөвлөмж | | Үүнээс Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Үүнээс Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Албан хаагчдад мөнгөн урамшуулал давхардуулан, илүү олгосон байна. | 1 | 1,712.5 | 1 | 1,712.5 | | | | | | | | |
| Байгууллагын оны шилдэг алба хаагчийг шагнаж урамшуулахдаа үндсэн цалинг 3 дахин нэмэгдүүлэн олгосон байна. | 1 | 15,481.5 | | | | | 1 | 15,481.5 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй ажил гүйлгээг бүртгэн, гүйцэтгэлийн үр дүнг тооцоогүй байна. | 1 | 15,000.0 | | | | | 1 | 15,000.0 | | | | |
| Дүн | 3 | 32,194.0 | 1 | 1,712.5 | | | 2 | 30,481.5 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд 162,067.6 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны тайлан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 827,114.9 мянган төгрөгийн орлогын 6 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 30,431.4 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, 1,900.0 мянган төгрөгийн 4 шийдвэрийг мэдээлээгүй, 76 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | 1 | 1,021,513.9 | | | | | 1 | 1,021,513.9 | | | | |
| Дүн | 1 | 1,021,513.9 | | | | | 1 | 1,021,513.9 | | | | |